



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/602

Номгон

Г

Г

Цагийн хязгаар шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 23 дугаар зүйлийн 23.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх цагийн хязгаарыг 1 дүгээр, аймгийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх цагийн хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Монгол Улсын Их Хурлын, Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах өдөр, санал авах өдрийн өмнөх болон дараагийн өдөр, сар бүрийн 1-ний өдөр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг тус тус хориглосугай.

3.Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газруудын цагийн хязгаарыг мөрдүүлж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр)-т, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд таниулах, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эерэг дадал зуршлыг бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, энэ төрлийн үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжиж, хамтран ажиллахыг нийт төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


5.Энэхүү захирамжийг холбогдох хууль, журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг

642311595

2.

даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-д даалгасугай.

6.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Цагийн хязгаарыг тогтоох тухай" аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/468 дугаар, 2023 оны А/428 дугаар, 2023 оны А/463, 2023 оны А/551 дүгээр захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын
10-ны өдрийн 4/602 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД СОГТУУРУУЛАХ
УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ЦАГИЙН ХЯЗГААР**

№	Худалдаа, үйлчилгээний төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар	
			Эхлэх	Дуусах
Баянхонгор сумд				
1	Хүнсний бөөний худалдаа	Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй	08:00	21:00
2	Хүнсний жижиглэн худалдаа, ая тухтай дэлгүүр /супер маркет/	Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй	08:00	23:00
3	Кафе, зоогийн газар	Согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	11:00	22:00
4	Баар, караоке, ресторан, лоунж	Согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	14:00	02:00
Бусад сумд				
1	Тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүр	Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй	09:00	23:00
2	Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газар	Согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	14.00	01:00

Аймгийн Засаг даргын А.О.О оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 1/602 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ЦАГИЙН ХЯЗГААР

№	Худалдаа, үйлчилгээний төрөл		Үйл ажиллагаа нээх	Үйл ажиллагаа хаах
1	Цахим тоглоомын газар	Үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	11:00	20:00
		Нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	11:00	20:00
2	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ		09:00	20:00

оОо